210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	55,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,200.00	39,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	139,000.00	139,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,000.00	76,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,265,200.00	1,265,200.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,265,200.00	1,265,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	320,443,500.00	320,443,500.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	301,500,400.00	301,500,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	301,500,400.00	301,500,400.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	6,807,300.00	6,807,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	6,807,300.00	6,807,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	12,135,800.00	12,135,800.00
122001	Хандив тусламж /дотоод/	12,135,800.00	12,135,800.00
122002	Хандив тусламж /гадаад/		
<b>14</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		1.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		1.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	23.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	8.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>22.00</b>	<b>23.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	15.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	3.00
650010	Гэрээт ажилтан	4.00	5.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/ төгрөгөөр /
			Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,433,536.00</b>	<b>77,362,631.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,433,536.00</b>	<b>77,362,631.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>32,433,536.00</b>	48,671,631.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	19,443,176.00	26,595,033.00
210101	Үндсэн цалин	19,443,176.00	26,595,033.00
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,500,000.00	3,208,067.00
210201	Тэтгэврийн даатгал	2,500,000.00	3,208,067.00
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	1,236,000.00
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт		1,236,000.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,026,700.00	4,530,930.00
210401	Бичиг хэрэг		441,500.00
210402	Тээвэр, шатахуун	23,700.00	3,972,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		117,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,003,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,113,660.00	8,114,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,663,660.00	6,488,000.00
210502	Хоол, хүнс	750,000.00	1,626,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	4,456,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,086,090.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар		370,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	530,831.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		530,831.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	350,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000.00	

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,000,000.00	28,691,000.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	28,691,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		22,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	6,291,000.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	32,433,536.00	77,362,631.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32,433,536.00	77,362,631.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,433,536.00	77,362,631.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь хүн амд нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ээлтэй, эрүүл орчинд шуурхай, жигд, хүртээмжтэй, чанартай үзүүлэх замаар үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн түвшин, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь төвийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулан, хүний нөөцийг чадавхижуулах, мэдээлэлийн тогтолцоо, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 331.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59.7 сая төгрөгөөр буюу 48.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	0.05	1.5	1.45
Урьдчилгаа			
Бараа материал	24.5	31.4	6.9
Нөөцийн бараа			
Үндсэн хөрөнгө	99.7	151.0	51.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>124.2</b>	<b>183.9</b>	<b>59.7</b>
Өр төлбөр	6.6	19.1	12.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	117.6	164.8	47.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>124.2</b>	<b>183.9</b>	<b>59.7</b>

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй, арилжааны банкинд 1 төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Авлага дансны үлдэгдэл 1.5 сая төгрөг болж нэмэгдсэн нь бусад зардлын тооцооны авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.4 сая төгрөг болж оны эхнээс 6.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 59.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, үнэ төлбөргүй 14.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, 66.5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 31.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл эм боох материалын үлдэгдэл 2.9 сая төгрөгөөр, аж ахуйн материалын үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр, бусад хангамжийн бараа материалын үлдэгдэл 7.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант оны эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуй, барилгын засвар, түлш шатах тослох, бусад хангамжийн материалын няравын тайлан гаргуулж тооцоо хийгээгүй, нягтлан бодогчийн зүгээс няравын бараа материалын хөтлөлтөнд хяналт тавиагүй, 19.9 сая төгрөгийн шатахуун, эмийн зарцуулалтын тооцоо хийгдээгүй, эмийн сангийн орлого, зарлагын бүртгэлд хяналт тавиагүй, эм, боох материалын зарим сарын эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 51.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, бусад эх үүсвэрээр 67.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсныг бүртгэлд тусгасан байна. Тайлант онд үндсэн хөрөнгө актлаагүй, үндсэн хөрөнгөд нийт 17.9 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 19.1 сая төгрөг болж 12.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад төлөх өглөг байна. Няравын бараа материалын тайланг гараагүй, санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрэн гүйцэт үдэж баримтжуулаагүйгээс өглөгийн тооцоог баталгаажуулах боломжгүй байна.

Тус эрүүл мэндийн төвд урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 47.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 47.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 107.7 сая төгрөгөөр буюу 28.9 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтийн орлого өмнөх оноос 27.7 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар өсөж, үнэ төлбөргүй авсан орлого, хөрөнгийн санхүүжилтийн орлого 80.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 101.3 сая төгрөгөөр буюу 30.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Цагааннуур Эрүүл мэндийн төвийн анхны төсвийг 320.4 сая төгрөгөөр баталсан ба төсвийн тодотголоор өөрчлөлт оруулаагүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 24 арга хэмжээг санхүүжүүлэхээр 320.4 сая төгрөгийн төсөв баталснаас Тусгай зориулалтын шилжүүлгээс 301.5 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 6.8 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 12.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 320.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 320.4 сая төгрөгийг зарцуулжээ. Тусгай зориулалтын шилжүүлгээс 301.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 6.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 12.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 320.4 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 78 хувийг цалин, 10.5 хувийг НДШ-ийн зардал, 1.9 хувийг тогтмол зардал, 4.5 хувийг хангамж бараа материалын зардал, 3.75 хувийг норматив зардал, 0.50 хувийг эд хогшил худалдан авах зардал, 0.22 хувийг томилолт, зочны зардал, 0.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс дээд шатны төсвөөс 77.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авч, цалингийн зардалд 26.6 сая төгрөгийг, НДШ-ийн зардалд 3.2 сая төгрөгийг, түлш халаалтын зардалд 1.2 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардалд 4.5 сая төгрөгийг, норматив зардалд 8.1 сая төгрөгийг, эд хогшил худалдан авах зардалд 4.5 сая төгрөгийг, томилолтын зардалд 0.5 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 28.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

## **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь 2021 онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 320.4 сая төгрөгийн 149 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт хийгдээгүй байна. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 96% хувьтай байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, хариуг хугацаанд ирүүлсэн байна. Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлэл хоцроож байршуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Гүйцэтгэлийн аудитаар үзэх шаардлагатай.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар 1.2 төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож, 105.8 төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр 1.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

1.Тайлант онд ажилчдад олгосон цалингаас нийт 19.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж авч, 18.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, оны эцсийн 0.6 төгрөгийн авлагыг хасаж тооцоход, 0.6 мянган төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

2. Тайлант онд ажилтан, албан хаагчдад 1.7 сая төгрөгийн вакцинжуулалтын урамшуулал олгосон бөгөөд ажилтнуудаас суутгах 0.2 сая төгрөгийн, байгууллагаас төлөх 0.2 мянган төгрөгийн бүгд 0.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг, мөн ажилчдаас суутгах 0.2 мянган төгрөгийн татварыг суутгаагүй, ажилчдын гарт олгох цалинг 0.4 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “ бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Аудитаар 105.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө.Үүнд:

1. Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 66.8 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 66.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуй, барилгын засвар, түлш шатах тослох, бусад хангамжийн материалын няравын тайлан гаргуулж тооцоо хийгээгүй, нягтлан бодогчийн зүгээс няравын бараа материалын хөтлөлтөнд хяналт тавиагүй байна.

Тайлант онд зарцуулсан 19.9 сая төгрөгийн шатахууны болон эмийн зарцуулалтын тооцоо хийгдээгүй, эмийн сангийн орлого, зарлагын бүртгэлд хяналт тавиагүй, эм, боох материалын зарим сарын эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй байна.

2. Оны эцэст үйл ажиллагаатай холбоотой 19.1 сая төгрөгийн өглөг үүсгэж тайлагнасан боловч няравын тайланг гараагүй, санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрэн гүйцэт үдэж баримтжуулаагүйгээс өглөгийн тооцоог баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1 дэх хэсэг, “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-д “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Цагааннуур тосгоны захирагчийн алба	3	107.0			2	1.2	1	105.8		